



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 253

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1, 5.3.2 дахь заалтад заасан шаардлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангах, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгаж, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагуудын удирдлагад тус тус зөвлөсүгэй.

3. Мэргэжлийн нэгдсэн холбоог улсын бүртгэлд бүртгэхтэй холбоотой үйлчилгээг “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-business.mn)-ээр дамжуулан цахим хэлбэрээр үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Улсын бүртгэлийн ерөнхий газар (Д.Давааням), “И-Монгол академи” УТҮГ (М.Баттулга)-т тус тус үүрэг болгосугай.

4. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Амарсайханд үүрэг болгосугай.




МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Б.ЭНХБАЯР

ШТА1206 9023100394 5498449



Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 253 дугаар тогтоолын хавсралт

## МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООГ БҮРТГЭХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Мэргэжлийн нэгдсэн холбоог шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгасныг болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх (цаашид “улсын бүртгэлд бүртгэх” гэх)-тэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2.Мэргэжлийн нэгдсэн холбоо (цаашид “МНХ” гэх)-г улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг тус тус баримтална.

1.3.МНХ-г улсын бүртгэлд бүртгэх чиг үүргийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгж хэрэгжүүлнэ.

1.4.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д хамаарах салбар, дэд салбар бүрд нэг хүртэл МНХ байна.

1.5.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх бүхий этгээд МНХ-г бүртгүүлэх хүсэлтийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад гаргана.

1.6.Улсын бүртгэлийн байгууллага МНХ-г улсын бүртгэлд бүртгэх эсэх шийдвэрийг Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан хугацаанд гаргаж, үндэслэл, тайлбарын хамт хүсэлт гаргагчид цаасан, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

1.7.Хүсэлт гаргах эрх бүхий этгээд МНХ-г улсын бүртгэлд бүртгүүлэхдээ Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасан улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлнө.

### Хоёр.Мэргэжлийн нэгдсэн холбоог шинээр үүсгэн байгуулсныг бүртгэх

2.1.МНХ-г шинээр үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаанд Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5, 6, 7, 8 дугаар зүйл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийг тус тус баримтална.

2.2.МНХ-г шинээр үүсгэн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэд Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан баримт бичгийг хавсаргана.

2.3.Улсын бүртгэгч МНХ-г бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор хүсэлт, түүнд хавсаргасан баримт бичгийн бүрдлийг хянаж, зөрчил илэрсэн тохиолдолд хүсэлт гаргагчид цаасан, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

2.4.Хүсэлт гаргагч энэ журмын 2.3-т заасан зөрчлийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор баримт бичгийг хуульд нийцүүлэн ирүүлсэн тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага 21 хоногийн дотор улсын бүртгэлд бүртгэнэ.

Гурав.Мэргэжлийн нэгдсэн холбоог  
өөрчлөн байгуулсныг бүртгэх

3.1.МНХ-г өөрчлөн байгуулсныг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаанд Иргэний хуулийн 31 дүгээр зүйл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 19, 20, 21 дүгээр зүйлийг тус тус баримтална.

3.2.МНХ-г өөрчлөн байгуулсныг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан баримт бичгийг хавсаргана.

3.3.МНХ-г өөрчлөн байгуулсныг улсын бүртгэлд бүртгэхэд энэ журмын 2.3, 2.4-т заасан хугацааг баримтална.

Дөрөв.Мэргэжлийн нэгдсэн холбоог татан  
буулгасныг бүртгэх

4.1.МНХ-г татан буулгасныг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаанд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23, 24, 25 дугаар зүйлийг тус тус баримтална.

4.2.МНХ-г татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэж, шийдвэрийг мэдэгдэлд хавсаргана.

4.3.Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэгт заасны дагуу эрх бүхий этгээд МНХ-г татан буулгасан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёроос зургаан сарын дотор холбогдох баримт бичгийг бүрдүүлэн улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.

4.4.МНХ-г татан буулгасныг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасан баримт бичгийг хавсаргана.

4.5.МНХ-г татан буулгасныг улсын бүртгэлд бүртгэхэд энэ журмын 2.3, 2.4-т заасан хугацааг баримтална.

4.6.МНХ-г татан буугдсан тухай мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэснээр улсын бүртгэлээс хасагдсанд тооцно.

#### Тав.Улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах

5.1.Улсын бүртгэгч Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлд тус тус зааснаас гадна дараах үндэслэлээр МНХ-г улсын бүртгэлд бүртгэхээс татгалзана:

5.1.1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрх бүхий этгээд хүсэлт гаргаагүй;

5.1.2.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1, 5.3.2 дахь заалтад заасан шаардлагыг хангаагүй;

5.1.3.улсын бүртгэлд бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу, эсхүл мэдээлэл нь зөрүүтэй, илт хуурамч;

5.1.4.улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлөөгүй;

5.1.5.улсын бүртгэлд хөдөлгөөн хийх эрхийг түдгэлзүүлсэн тухай эрх бүхий этгээдийн шийдвэр гарсан;

5.1.6.тухайн улсын бүртгэлийн асуудлаар хууль хяналтын байгууллагаас эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа;

5.1.7.улсын бүртгэлийн мэдээллийн санд эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбар, дэд салбарын ангилалд МНХ бүртгэлтэй бол ижил ангилалд бүртгүүлэхээр ирүүлсэн;

5.1.8.энэ журмын 2.4-т заасан хугацаанд зөрчлийн үндэслэлээ арилгаж, холбогдох баримт бичгийг ирүүлээгүй.

5.2.Улсын бүртгэгч энэ журмын 5.1-д заасан үндэслэлээр улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг хуулийн этгээдийн хувийн хэрэгт хавсаргана.

5.3.Хүсэлт гаргагч энэ журмын 5.1-д заасан татгалзах үндэслэлийг арилгасны дараа улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг дахин гаргаж болно.

5.4.МНХ-г улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг хүсэлт гаргагч үндэслэлгүй гэж үзвэл Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу гомдол гаргах эрхтэй.

### Зургаа.Мэргэжлийн нэгдсэн холбооны мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэх

6.1.МНХ-ны мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагаанд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийг баримтална.

6.2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан мэдээлэлд өөрчлөлт оруулсан шийдвэр, холбогдох баримт бичгийг тухайн МНХ ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.

6.3.МНХ-ны мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан баримт бичгийг хавсаргана.

6.4.МНХ-ны мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд энэ журмын 2.3, 2.4-т заасан хугацааг баримтална.

### Долоо.Мэргэжлийн нэгдсэн холбоог бүртгэхэд тавих шаардлагыг тогтоох

7.1.Улсын бүртгэлийн байгууллага Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт заасны дагуу МНХ-г улсын бүртгэлд бүртгэхэд шаардлагатай нэмэлт баримт бичиг, лавлагаа, мэдээлэл, тайлбарыг статистик, татвар, гааль, өрсөлдөөний асуудал эрхэлсэн байгууллага болон бусад холбогдох байгууллагаас гаргуулан авна.

7.2.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1, 5.3.2 дахь заалтад заасан шаардлагыг тогтооход тусгай мэдлэг, мэргэшил шаардлагатай тохиолдолд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын шийдвэрээр шинжээч томилж болно.

7.3.Шинжээч нь тухайн ангиллын МНХ-ны эрх бүхий этгээдтэй Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5, 3.1.6, 3.1.11 дэх заалтад заасан хамааралгүй байна.

7.4.Шинжээч нь тогтоосон хугацаанд асуудлыг бүрэн, бодитой, хараат бусаар шинжилж, үнэн зөв дүгнэлтийг бичгээр гаргана.

7.5.Энэ журмын 7.2-т заасан шинжээчийн үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, ажлын хөлс тооцох аргачлалыг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтад заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

7.6.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтад заасан гишүүдийн үйлдвэрлэл, борлуулалт, худалдан авалт нь тухайн салбарын зах зээлийн 50-иас дээш хувийг эзэлж буй эсэх асуудлаар тухайн салбарын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны

байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулж, санал, дүгнэлт гаргуулж болно.

7.7.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.2 дахь заалтад заасан шаардлагыг тогтоохдоо Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлсэн сүүлийн жилийн санхүү, татварын тайлан, статистикийн мэдээлэл болон шаардлагатай бусад баримт бичгийг үндэслэнэ.

7.8.Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтад заасан шаардлагыг тогтоохдоо Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан хамаарал бүхий этгээдийн гишүүнчлэлийг нэгтгэн тооцно.

7.9.Улсын бүртгэл хөтлөхөд шаардлагатай төрийн бусад байгууллагын мэдээллийг нийтийн мэдээллийн дэд бүтцээс авч баталгаажуулна.

7.10.Улсын бүртгэлийн байгууллага Мэргэжлийн нэгдсэн холбооны улсын бүртгэл хөтлөхөд шаардлагатай мэдээллийг улсын бүртгэлийн байгууллагын мэдээллийн сангаас баталгаажуулна.

Найм.Гомдол, маргааныг хянан шийдвэрлэх

8.1.МНХ-ны улсын бүртгэлтэй холбоотой гомдол, маргааныг Захиргааны ерөнхий хууль болон Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

---o0o---